

Хоёр хоногийн олно тус улсад тагнуулаар ажиллаж амьдарч байсан Хойд Солонгосын тагнуулчийг саатуулсан билээ. Эх орноосоо дүрвэн гарсан Хойд Солонгосын иргэд дундаас тус улсад хамгийн ондор албан тушаал буюу торийн ажилтан хэмээх албыг хааж байсан тагнуул гэгдэх Юв (33) , 2004 онд Омнод Солонгос улсад дүрвэн ирсэн нэгэн богоод тус улсад дэндүү сайн дасан зохицон амьдарч байсан тул хариуцаж байсан Омнод Солонгос байцаагч нь хүртэл түүнийг оргомол хүүхдээ хэмээн үзэж байсан ажээ.

Хойд Солонгосын тагнуулч Юв нь хятад улсад торсон Солонгос үндэстэн хэдий ч Хойд Солонгост байх ах дүүсийнхээ гар дээр оссон хятад болон Солонгос хэл бүрэн эзэмшсэн гэнэ. Тэрээр насанд хүрсэн хойноо хятад улсад буцаж ирэн амьдарч байсан хятад улсын паспортой нэгэн богоод Хойд Солонгосоос дүрвэгчдийн тоонд багтан тус улсад ирж чадсан тодийгвй , саяхан болтол Омнод Солонгос улс дахь Хойд Солонгосын дүрвэгсдийн асуудлыг хариуцсан торийн ажилтан болсон цорын ганц хүн нь байжээ.

Ажлаа хийж байх хугацаандаа хятад болон Хойд Солонгос руу олон ч удаа зорчиж ,Омнод Солонгос улсад дүрвэн очсон Хойд Солонгосчуудын мэдээллийг оорийн биеэр аваачиж огдог байсан тагнуул Юв нь , Хойд Солонгосоос дүрвэгсдийн эрх ашгийг хамгаалах олон нийтийн сайн дурын байгууллагуудын ходолгоон , жагсаал, уулзалт зэргийг зохион байгуулдаг үнэнч шударга гэгддэг ажилтан байсан байна.

Совл хотын дарга Пак Вон Сүгийн гадаадын иргэд болон Хойд Солонгосоос дүрвэгсдэд үзүүлэх нийгмийн халамжийг үзүүлэх, тэднийг ондор албан тушаалд томилох зэрэг ажлуудын эхлэлийг тавьснаас болж ийнхүү гадаадын тагнуулуудыг ажиллуулах боломж олголоо хэмээн олон иргэд үзэж байгаа богоод одоогоор тус улсад дүрвэн ирээд буй 25 мянган Хойд Солонгосын дүрвэгсдийн мэдээлэл түүгээр дамжин эх оронд нь очсон гэж үзэж болох юм байна.